

**ХЭНТИЙ АЙМГИЙН ӨМНӨДЭЛГЭР СУМЫН НУТАГТ ОРШИХ “САЙХАНЫ ХӨНДИЙН  
АЛТНЫ ШОРООН ОРД” ТӨСЛИЙН 2022 ОНД ХЭРЭГЖҮҮЛСЭН БАЙГАЛЬ ОРЧНЫ  
МЕНЕЖМЕНТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ  
БИЕЛЭЛТИЙН ТАЙЛАН**

**(АШИГТ МАЛТМАЛЫН ТУСГАЙ ЗӨВШӨӨРЛИЙН ДУГААР: МУ-006505)  
(АЖ АХУЙН НЭГЖИЙН РЕГИСТРИЙН ДУГААР: 5029953)**

**ХЯНАСАН: БОАЖЯ-НЫ ХБОБНУГ-ЫН  
МЭРГЭЖИЛТЭН \_\_\_\_\_ ( \_\_\_\_\_ )**

**БИЕЛЭЛТИЙГ ТАЙЛАГНАСАН:  
“АЛТАЙХАНГАЙ БҮРД” ХХК-ИЙН ЗАХИРАЛ \_\_\_\_\_ (Б.БАЯРАА)**

**“АЛТАЙХАНГАЙ БҮРД” ХХК-ИЙН  
МЭРГЭЖИЛТЭН \_\_\_\_\_ (С.ДЭЛГЭРДАЛАЙ)**

**2022 он**

## ГАРЧИГ

1. ОРШИЛ.....	3
2. ТӨСЛИЙН ТОВЧ ТАНИЛЦУУЛГА .....	<b>Error! Bookmark not defined.</b>
2.1.Ерөнхий мэдээлэл .....	<b>Error! Bookmark not defined.</b>
2.2.Төслийн байршил.....	<b>Error! Bookmark not defined.</b>
3.СӨРӨГ НӨЛӨӨЛЛӨӨС УРЬДЧИЛАН СЭРГИЙЛЭХ, БУУРУУЛАХ АРГА ХЭМЖЭЭНИЙ ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ БИЕЛЭЛТ.....	5
3.1. Сөрөг нөлөөллөөс урьдчилан сэргийлэх, бууруулах арга хэмжээний төлөвлөгөөний биелэлт .....	<b>Error! Bookmark not defined.</b>
3.2. Нөхөн сэргээх арга хэмжээний төлөвлөгөөний биелэлт.....	7
3.3.Биологийн олон янз байдлыг дүйцүүлэн хамгаалах төлөвлөгөөний биелэлт.....	8
3.4.Нүүлгэн шилжүүлэх нөхөн олговор олгох арга хэмжээний биелэлт.....	8
3.5.Түүх соёлын өвийг хамгаалах арга хэмжээний төлөвлөгөөний биелэлт.....	8
3.6.Хог, хаягдлын менежментийн төлөвлөгөөний биелэлт .....	9
3.7.Осол, эрсдэлийн менежментийн төлөвлөгөөний биелэлт.....	11
3.8.Орчны хяналт шинжилгээний хөтөлбөрийг мэргэжлийн байгууллагаар хийлгүүлсэн бөгөөд хээрийн судалгааны үр дүнг тайланд хавсаргав. ....	11
3.9.Байгаль орчны менежментийн төлөвлөгөөг хэрэгжүүлэх удирдлага зохион байгуулалтын төлөвлөгөө .....	14
3.10.Олон нийтэд тайлагнах хуваарь, төлөвлөгөөний биелэлт.....	15

## 1. 2022 ОНЫ УУЛЫН АЖЛЫН ГҮЙЦЭТГЭЛИЙН ТОВЧ ТАНИЛЦУУЛГА


**Төслийн ангилал:** “Алтайхангай бүрд” ХХК-ны “Сайханы хөндийн алтны шороон ордыг ил аргаар олборлох” төсөл нь Хэнтий аймгийн Батширээт, Өмнөдэлгэр сумдын нутагт Сайханы гол нэртэй газарт MV-006505 тоот тусгай зөвшөөрөлтэйгөөр 378.49 га талбайд үйл ажиллагаагаа явуулдаг.

Уурхай нь 2022 оны 5-р сарын 1-нээс үйл ажиллагаагаа эхлэн 228.5489 мян.м<sup>3</sup> хөрс хуулалт хийж, 54.315 мян.м<sup>3</sup> элс угаан 31.89 кг алт ашиглахаар төлөвлөн ажиллаж байна.

**Алтны ордыг ил аргаар олборлох төслийг хэрэгжүүлэгч аж ахуйн нэгжийн мэдээлэл:**

Хүснэгт 1. “Алтайхангай бүрд” ХХК-ийн мэдээлэл

ААНэгжийн нэр	Улсын бүртгэлийн дугаар	Үйл ажиллагааны чиглэл	ААН-ийн хаяг, байршил
Алтайхангай бүрд ХХК	9011279076	Гадаад худалдаа Ашигт малтмал	Улаанбаатар, Сүхбаатар, 6-р хороо, бага тойруу, 24, “Монреимплекс” 303 тоот



Зураг 1. Төсөл хэрэгжих газрын байршил

**Уурхайн барилга байгууламжууд:** 2009 онд уурхайн түр тосгоныг байгуулж олборлолтын үйл ажиллагаа эхэлсэн. Үүнд:

1. **Захиргаа, аж ахуйн барилга байгууламжууд** - (контор, ажилчдын орон сууц, ОО, халуун ус, спортын талбай)
2. **Үйлдвэрийн барилга байгууламжууд**- (засварын газар, шилх баяжуулах цех, агуулахууд, дизель цахилгаан станц, шатахуун түгээх станц нь 20тн-ын багтаамжтай 1ш резервуар, 20тн-ын 1ш ёмкость, цахилгааны шугам, элс угаах цэг г.м)зэргээс бүрдэнэ.





**Техник, тоног төхөрөөмжүүд:** CAT-08 маркийн бульдозер, Hyundai RXLJ-305 1.2м<sup>3</sup> утгуурын багтаамжтай эксковатор, HOWO маркийн өөрөө буулгагч автосамосвал, Hyundai RX-LC-7 маркийн эксковатор, CAT-D6 маркийн бульдозер, LG-50 дугуйт ачигч, баяжуулахын угаах төхөөрөмж, баяжуулахын ширээ болон бусад тоног төхөөрөмжүүд

**Усан хангамж:** Баяжуулах үйлдвэрийн усан хангамжийг уурхайн гүний шүүрлийн усаар хангана. Уурхайн олборлолтоос үүссэн хоосон орон зайг усан сан болгож ашиглах бөгөөд уг усан санд хуримтлагдсан усыг эргүүлж ашиглах байдлаар үйлдвэрийн усан хангамжийг шийдвэрлэж байна. Унд ахуйн усан хангамжаа Сайханы голоос зөөвөрлөж хангадаг.

**Цахилгаан хангамж:** Усаар хангах насос, тосгоны болон уурхайн гэрэлтүүлгийг дизель станц T20HK-M126-г ашиглан хангаж байна. Бусад хөдөлгүүрүүдийн цахилгааныг Японы Duna-100 квт станцаар хангаж байна.


## 2.СӨРӨГ НӨЛӨӨЛЛӨӨС УРЬДЧИЛАН СЭРГИЙЛЭХ, БУУРУУЛАХ АРГА ХЭМЖЭЭНИЙ ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ БИЕЛЭЛТ

Хүснэгт 1. Сөрөг нөлөөллөөс урьдчилан сэргийлэх, бууруулах арга хэмжээний төлөвлөгөөний биелэлт

Гол болон болзошгүй сөрөг нөлөөлөл	Сөрөг нөлөөллийг арилгах, бууруулах арга хэмжээ	Хэрэгжүүлсэн арга хэмжээ
<b>НЭГ. АГААР ОРЧИН ЧАНАР</b>		
Олон салаа замаас үүсэх тоосжилт	Зогсоол, замын тэмдгийг засварлах, сэргээх	Уурхайн дотоод болон гадаад замын дагуу зогсоолын тэмдэг-1, хориотой бүс-1, хурдны хязгаарын тэмдэг-1, нийт 3ш тэмдэг шинээр байрлуулж, өмнө жилүүдэд байрлуулсан замын тэмдэг тэмдэглэгээнүүдийг сэргээн зассан. <div style="display: flex; justify-content: space-around;">    </div>
Агаарын чанарын менежментийн тогтолцоог сайжруулах	Автотээврийн болон өөрөө явагч хэрэгсэлд ногдох жилийн төлбөр төлөх	Уурхайн олборлолтын үйл ажиллагаанд ашиглагдаж буй нийт 5ш хүнд даацын автомашиныг Агаарын бохирдлын тухай хууль тогтоомжийн дагуу оношилгоонд оруулж, татварыг бүрэн төлж барагдуулсан. <div style="display: flex; justify-content: space-around;">  </div>
<b>ХОЁР. ХӨРСӨН БҮРХЭВЧ</b>		
Хөрсний элэгдэл, эвдрэл	Ашиглахгүй болсон шороон замыг хаах, нөхөн сэргээх	Уурхайн олборлолтын С-21 блокийн ашиглахгүй болсон шороон замыг хааж тэгшилэн нөхөн сэргээлт хийсэн.
Хөрсний бохирдол	Тусгай зөвшөөрлийн талбайн хүрээнд хог хаягдлыг тогтмол цэвэрлэх	Уурхайн суурьшлын бүс орчимд хог хаягдлын төвлөрөл үүсэхээс сэргийлж хог хаягдлын цэвэрлэгээг тогтмол хийж ирсэн
<b>ГУРАВ. УСАН ОРЧИН</b>		
Гадаргын усны нөөц,	Ус хуримтлуулах сангийн бүрэн	. Усан сангийн эргэлтийн усны шугам хоолойн битүүмжлэл, аюулгүй байдлыг шалгаж

горимд өөрчлөлт орж болзошгүй	бүтэн байдлыг байнга шалгах	аваарийн нөөц далан, шинээр байгуулсан. Ус хуримтлуулах сан дүүрч халиа үүссэн байдал байхгүй, шугам хоолойнууд хэвийн ажиллаж байна.
	Голын урсац бүрэлдэх эх, усны эх үүсвэрийн орчмыг хамгаалах, эрүүл ахуйн бүсийг тодорхойлсон самбар байршуулах	Сайханы голын эргээс 200м зайд “Сайханы голын Энгийн хамгаалалтын бүс 200м” бичвэр, хамгаалалтын бүсэд хориглох үйл ажиллагааны таних тэмдэг бүхий самбарыг байршуулсан.

**ДӨРӨВ. УРГАМЛАН НӨМРӨГ**

Төслийн талбай орчимд ургамлан нөмрөг талхлагдах	Мод тарих		
Ой хээрийн түймрээс гарснаар ой модод сөргөөр нөлөөлөх	-БО, Ой хээрийн түймрээс урьдчилсан сэргийлэх сургалтыг тогтмол явуулах	Уурхайн нийт 28 ажилчдад ой хээрийн түймрээс урьдчилан сэргийлэх, галын аюулгүй байдлын сургалтыг ХАБЭА-ын ажилтан тогтмол явуулдаг бөгөөд гал гарсан тохиолдолд авах арга хэмжээний талаар заавар зөвлөмжийг өгч ажилласнаар гал түймрийн аюул гараагүй болно.	 <p><b>АЖЛЫН БАЙРАНД</b> Галын аюулаас сэргийлгээ</p> <p><b>ХОРИГЛОНО</b></p> <ul style="list-style-type: none"> <li>Галын хэр, хөлий, гал унтраах хэрэгслүүдийг кааж барца, материал хураахыг катуу хориглоно.</li> <li>Цахилгааны уртаслагч, залуурын хэт ачааллаж болохгүй. Гэмтэлтэй цахилгаан хэрэгслүүдийг ашиглалтаас хясаж байх ёстой.</li> <li>Ил галыг хяналтгүй орхиж болохгүй.</li> <li>Хэрэв хөгийн сав талгүй бол шатамхай материал, хөг хялж болохгүй.</li> <li>Шатамхай урсгалд орж хөхийн бодис, материалуудыг нэг дөр хадгалж болохгүй.</li> </ul> <p><b>АВАХ АРГА ХЭМЖЭЭ</b></p> <ul style="list-style-type: none"> <li>Төног тээвэрэнхийн эвдрэл, гэмтэл, хэт ачааллаас сэргийлэн төлөвлөгөөт зөсвэр үйлчилгээг сайн хийж хэрэгтэй.</li> <li>Галнууд таслагч зэрэг ил гал, оч үүсгэх баян ашиглахдаа ажлын аюулыг сайтар тооцож, орчноо шалгана.</li> <li>Галын аюулаас урьдчилан сэргийлэх мэдлэг, сургалт амилтан амилгасаддаа өгнө.</li> <li>Яг хөндийн өдөр бүр цэвэрлэж, ажлын бичирвэр хөлдүүлнэ.</li> <li>Ажлаа дуусаад буй цахилгаан төног тээвэрэнхийг унтраана.</li> </ul>

**ТАВ.АМЬТНЫ АЙМАГ**

Уурхайн ойр орчмын газарт нутагладаг ан амьтдын амьдрах орчинд шууд бус байдлаар нөлөөлөх	Хулгайн антай тэмцэх, уурхайн талбай орчимд тогтмол эргүүл хийх	Уурхай нь жилийн 365 хоног харуул хамгаалалттай байдаг. Хулгайн антай тэмцэх зорилгоор уурхайн ойр орчмын талбайд өдөрт нэг удаа эргүүл хийдэг. Хулгайн анчид болон зөвшөөрөлгүй мод бэлтгэж байгаа иргэдийг илрүүлэх цаашлаад Сумын эрх бүхий албан тушаалтнууд болон Экологийн цагдаагийн албанд мэдэгдэх мэдээлэл холбоогоор бүрэн хангагдсан. /G-mobile гар утас, богино холбооны станц /
---	---	---

### 3.НӨХӨН СЭРГЭЭХ АРГА ХЭМЖЭЭНИЙ ТӨЛӨВЛӨГӨӨГИЙ БИЕЛЭЛТ

2022 онд 4.5 га талбайд техникийн нөхөн сэргээлт хийхээр төлөвлөсөн.

Хүснэгт 2. Нөхөн сэргээлтийн төлөвлөгөөний биелэлт

Нөхөн сэргээлтийн арга хэмжээ	Хэмжих нэгж	Хэрэгжүүлсэн арга хэмжээ
<b>Техникийн нөхөн сэргээлт</b>	Ухашийн ирмэг, Овоолгын хажууг хэвгийжүүлэн налуулах Хэвгийжүүлсэн, нөхөн дүүргэсэн гадаргууг хэлбэржүүлэх, тэгшлэх, тэгшилсэн талбайг дэвсгэржүүлэх Шимт хөрсний овоолгоос шимт хөрс ухаж ачих, тээвэрлэн буулгаж, хучих ажил	2022 онд 7.1 га талбайд техникийн нөхөн сэргээлт хийсэн. Нөхөн сэргээлт хийсэн талбайн байршлыг Маркшедрин хэмжилт хийсэн тайлангаас харж болно. Нөхөн сэргээлт хийсэн талбайн булангийн цэгүүд:
<b>Биологийн нөхөн сэргээлт</b>	Биологийн нөхөн сэргээлт (нэг наст болон олон наст ургамлыг тариална) Нөхөн сэргээсэн талбайн дараах хяналт мониторингийн ажлын зардал	100 кг согоовор болон ерхөгний үр худалдан авсан бөгөөд тариалалт хийгдээгүй. Уурхай нь үйл ажиллагааны турш нийтдээ 30-аад га газарт биологийн нөхөн сэргээлт хийж мод тариалсан бөгөөд жил бүр усалгаа, арчилгааг хийснээр ургалтын хувь нэмэгдэж байна. Мөн талбайд ургасан хөл газрын ургамлыг түүж цэвэрлэсэн.

#### 4.БИОЛОГИЙН ОЛОН ЯНЗ БАЙДЛЫГ ДҮЙЦҮҮЛЭН ХАМГААЛАХ ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ БИЕЛЭЛТ

Дүйцүүлэн хамгаалал хийх аргачлалд зааснаар жижиг төслүүдийн хувьд дүйцүүлэн хамгааллын хамтарсан байдлаар хэрэгжүүлэх боломжтой бөгөөд гагцхүү нөлөөллийн хэмжээг тогтоох шаардлагатай юм. Иймээс тус компани дүйцүүлэн хамгаалал хийх арга хэмжээг “Тэрбум мод” үндэсний хөдөлгөөнд нэгдэн 2.0 га талбайд мод тарих ба биологийн олон янз байдалд эергээр нөлөөлөх байдлаар аймаг, сумын холбогдох байгууллагуудтай хамтран төлөвлөх боломжтой байна.

Хүснэгт 3. Дүйцүүлэн хамгаалах арга хэмжээний төлөвлөгөөний биелэлт

Дүйцүүлэн хамгаалах зорилт	Хамгаалах арга хэмжээ	
“Тэрбум мод” үндэсний хөдөлгөөнд нэгдэн мод тарих	Суулгац худалдан авах /чацаргана/ 1000ш 2 сая Хөрс бэлдэх 500 мян Арчилгаа хийх 200 мян	“Тэрбум” үндэсний хөдөлгөөнд нэгдэн 2.5 сая төгрөгийн хандив тусламж үзүүлсэн.

#### 5.НҮҮЛГЭН ШИЛЖҮҮЛЭХ НӨХӨН ОЛГОВОР ОЛГОХ АРГА ХЭМЖЭЭНИЙ БИЕЛЭЛТ

Уурхайн сөрөг нөлөөллийн бүсэд орших иргэд, оршин суугчид, айл өрх, байгууллагыг зайлшгүй нүүлгэх шаардлагатай болсон тохиолдолд тэднийг нүүлгэн шилжүүлэх төлөвлөгөө боловсруулна. Ингэхдээ тэдэнд өгөх нөхөн олговрыг хэдийд өгөх, шинэ газарт нүүлгэн шилжүүлэх үйл ажиллагааг тэдний саналыг харгалзан хэдийд зохион байгуулахыг тодруулан тусгана. Энэхүү төслийн хувьд иргэд оршин суугчдад үзүүлэх хүчтэй сөрөг нөлөөлөл байхгүй байна.

Хэрэв цаашид нүүлгэн шилжүүлэлт нөхөн олговортой холбоотой асуудал гарвал газар болон бусад үл хөдлөх хөрөнгөтэй холбоотой өмчлөх, хуваарилах, бэлэглэх, шилжүүлэх үйл явцыг Монгол улсад дараах хууль тогтоомжуудаар зохицуулна. Үүнд:

1. Үндсэн хууль (1992);
2. Газрын тухай хууль (2002);
3. Монгол Улсын иргэнд газар өмчлүүлэх тухай хууль (2003);
4. Иргэний тухай хууль (2002) багтана.






## 6.ТҮҮХ СОЁЛЫН ӨВИЙГ ХАМГААЛАХ АРГА ХЭМЖЭЭНИЙ ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ БИЕЛЭЛТ

Төслийн талбай болон түүний нөлөөллийн бүсэд ямар нэгэн түүх соёлын дурсгалт зүйл ба археологийн олдвортой газар байхгүй. Төслийн хэрэгжилтийн явцад ямарваа нэгэн түүх соёлын дурсгалт зүйл олдох үед холбогдох хууль тогтоомжинд заасны дагуу засаг захиргааны байгууллага болон холбогдох байгууллага болох ШУА-ийн Түүхийн хүрээлэнд даруй мэдэгдэж төслийн үйл ажиллагааг түр хугацаагаар зогсооно.

## 7.ХОГ ХАЯГДЛЫН МЕНЕЖМЕНТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ БИЕЛЭЛТ

Хүснэгт 4. Хог, хаягдлын менежментийн төлөвлөгөөний биелэлт

Гол болон болзошгүй сөрөг нөлөөлөл	Сөрөг нөлөөллийг арилгах, бууруулах арга хэмжээ	Хэрэгжүүлсэн арга хэмжээ	
<p>Ахуйн хэрэглээний хог хаягдал Буруу хадгалсан хог хаягдал түүний эх үүсвэрээс үнэрийн бохирдол гарах</p>	<p>Уурхайн ажилчдад зориулан хог хаягдлын ангилан ялгаж хаях талаар заавар зөвлөмж бүхий зурагт хуудас, зөвлөмжүүдийг байршуулах</p>	<p>Уурхайн үйл ажиллагаанаас гарч буй хог хаягдлыг ахуйн болон аюултай гэж ангилан хадгалах 4ш савыг байршуулан хаягжуулсан. Ахуйн хэрэглээнээс үүсч буй хог хаягдлыг ангилан хаях заавар, зөвлөмж, зурагт хуудсуудыг ажилчдын орон сууц, хоолны газарт нүдэнд ил харагдахуйц газар байршуулсан.</p>	
	<p>Хог хаягдлыг ангилан ялгах цэг байгуулах</p>	<p>Кемпийн баруун урд талд хог хаягдал хадгалах түр цэг байгуулж, талбайг цементлэн, ахуйн хог хаягдал хадгалах 3ш сав, аюултай хог хаягдал хадгалах сав 1ш-ийг тус тус хаягжуулан байршуулсан. Орон нутгийн төсөвт хог хаягдлын үйлчилгээний төлбөр 1338000 төг төвлөрүүлсэн.</p>	

	<p>Хатуу хог хаягдлыг уурхайн дотоод зардлаар тээвэрлэж тусгай зориулалтын хогийн цэгт хаях</p>	<p>Уурхайн үйл ажиллагаанаас үүссэн энгийн хог хаягдлыг орон нутгийн эрх бүхий холбогдох байгууллагатай тээвэрлүүлэх гэрээ байгуулан ажиллаж байна.</p>		
--	---	---	---	--

## 8.ОСОЛ, ЭРСДЭЛИЙН МЕНЕЖМЕНТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ БИЕЛЭЛТ

Хүснэгт 5. Осол, эрсдэлийн менежментийн төлөвлөгөөний биелэлт

Болзошгүй аюул осол, сөрөг нөлөө	Урьдчилан сэргийлэх бууруулах, арилгах арга хэмжээ	Хэрэгжүүлсэн арга хэмжээ
<b>ХХАА-ны дүрэм журам зөрчигдөж үйлдвэрийн осол гарах</b>	Ажилтан бүрийг хөдөлмөр хамгаалах хэрэгслээр хангах	Уурхайн нийт 28 ажилчдыг хавар зуны болон намар өвлийн хувцас болон бээлий, маск, чихэвч зэргээр ханган ажиллаж байна.
	Уурхайн техник тоног төхөөрөмж, тээврийн хэрэгслийн бүрэн бүтэн байдалд байнгын хяналт тавих, шаардлагатай үед засвар үйлчилгээг нарийн хяналт дор хийх	Техникүүдийн үзлэг, оношилгоог цаг тухай бүрд нь хийж, техникийн доголдол, бүрэн бүтэн байдлыг байнга хянаж хийгдсэн засвар, үйлчилгээг ажлын наряд болон техникийн паспортод тэмдэглэж ажилладаг. Тайлант хугацаанд тус ордын үйл ажиллагаатай холбоотойгоор ямар нэгэн доголдол бүртгэгдээгүй болно.
	Ажилчдад анхан шатны тусламж үзүүлэх арга зааврыг эзэмшүүлэх, анхан шатны тусламжийн эм, тариа, багаж хэрэгслийг хяналтын өрөө эсвэл ажлын байранд ил харагдахаар газарт байрлуулах	Уурхайн ажилчдын орон сууцанд нүдэнд ил харагдахуйц газарт анхны тусламж үзүүлэх зөвлөмж бүхий самбарыг байршуулан, анхны тусламжийн хайрцаг 3ш-ийг ажилчдын сууц, оффис зэрэг газруудад байрлуулсан.
<b>Галын аюулгүй байдлыг хангаагүйгээс гал түймрийн осол аваарт өртөх</b>	Болзошгүй аюул ослын үед ашиглах бүрэн ажиллагаатай галын хор, багаж хэрэгслүүдийг бүх объектуудад байрлуулах, галын аюулын үед ашиглах ослын гарцын зураглал хийж байршуулах	Шатахуун хадгалах байр, цахилгаан станц, оффис, ажилчдын байранд галын хорыг стандартын хэмжээнд байрлуулан, гал унтраах багаж хэрэгслүүдийг тусгай байранд хадгалж байна. Галын хорны бүрэн бүтэн байдлыг сард 1 удаа шалгаж хяналтын картыг хөтөлдөг. Мөн ажилчдын байранд гарцын тэмдэг тэмдэглэгээг байрлуулсан.
	Ажилчдыг галын хор болон бусад хэрэгслийг ашиглаж сургах, дадлага эзэмшүүлэх зэрэг зохион байгуулалтын арга хэмжээг авах	ХАБЭА-ын ажилтан, уурхайн дарга нар хамтран ажилчдад галын хор ажиллуульж сурах дадлага сургалтыг зохион байгуульж, галын хор ажиллуулах заавар, зөвлөмжийг ажлын байранд ил харагдахуйц газар байршуулсан.

Болзошгүй аюул ослын үед орон нутгийн эмнэлэг болон бусад байгууллагуудтай хамтран ажиллах талаар гэрээ байгуульж ажиллаж байна.

Ажиллагсдыг түймэр унтраах арга барилд сургах, гал гарсан тохиолдолд шуурхай унтраах арга хэмжээ авах сургалтанд хамруульж, гарын доорх материалаар хангасан.

Уурхайн ажилчдыг хөдөлмөр хамгаалал аюулгүй ажиллагааны зааварчилгаа өгч, эрүүл ахуй, аюулгүй ажиллагааг хангах сургалтанд хамруульж, семинар зохион байгуулсан.



Зураг 2. Яаралтай түргэн тусламжийн арга хэмжээ авах эмийн сан



Зураг 3. Ажлын байран дахь хөдөлмөр хамгаалал аюулгүй ажиллагааны зааварчилгаа, самбарууд

**9.ОРЧНЫ ХЯНАЛТ ШИНЖИЛГЭЭНИЙ ХӨТӨЛБӨРИЙГ МЭРГЭЖЛИЙН БАЙГУУЛЛАГААР ХИЙЛГҮҮЛСЭН БӨГӨӨД ХЭЭРИЙН СУДАЛГААНЫ ҮР ДҮНГ ТАЙЛАНД ХАВСАРГАВ.**

Хүснэгт 6. Орчны хяналт, шинжилгээний хөтөлбөрийг хэрэгжүүлсэн биелэлт

Байгаль орчны бүрэлдэхүүн	Хяналт шинжилгээ хийх үзүүлэлт	Хэрэгжүүлсэн арга хэмжээ
Агаар орчин	Агаарын тоосжилт (PM 2.5, PM 10)	Уурхай орчмын агаарын PM 2.5 болон PM 10 тоосонцрын хэмжиж үр дүнг Монгол Улсын агаарын чанарын стандарт MNS 4585:2016-тай харьцуулахад зөвшөөрөгдөх дээд хэмжээнээс хэтрээгүй байна. Нийт 2 цэгээс хэмжилт хийсэн.
Усан орчин	Физик шинж чанар Химийн найрлага	Сайхан голын уснаас холбогдох аргачлалын дагуу дээж авч усны ерөнхий шинжилгээг “Нарт ШУҮН Консалтинг” ХХК-ийн итгэмжлэгдсэн лабораторид шинжлүүлэв. /Шинжилгээний хариуг хавсаргав./ Шинжилгээнд нийт 108 000 төгрөг зарцуулав.
Хөрсөн бүрхэвч	Хөрсний зарим хүнд металл	Төслийн талбайд нийт 4 цэгээс хөрсний дээж авч, хөрсний агрохимийн 1 дээжийг 300-500 гр, хүнд металлын 1 дээжийг 200-300 гр, хөрсний эрүүл ахуйн 1дээж 100 гр хэмжээтэй авсан. Хөрсний агрохимийн болон хүнд металл шинжилгээг “Нарт ШУҮН Консалтинг” ХХК-ийн хөрс судлалын итгэмжлэгдсэн лабораторид шинжлүүлэв. /Шинжилгээний хариуг хавсаргав./



“НАРТ ШУУН КОНСАЛТИНГ” ХХК  
ХӨРСНИЙ ИТГЭМЖЛЭГДСЭН ЛАБОРАТОРИ



Монгол улс, Улаанбаатар хот, Сүхбаатар Хайрхан дүүрэг, 19-р хороо, ҮЗГ, ЗК 17024 Ш/х 10  
Утас: (976)-99176123, 99231836

E-mail: nartsumming@gmail.com

№ 22/10-04/1

Зөхөөлөгч: “Анлд Анлид” ХХК

Дээж авсан цэг: “Алтайн хангай бүрд” ХХК, Хэнтий аймаг, Өвнөдэлгэр сум, Сайхан гол  
Сорьц авсан огноо: 2022 оны 09 сар 28 өдөр  
Шалгахдаг зүйлсийн огноо: 10 сарын 04

Харилцах утас:

1. ХӨРСНИЙ ХИМИЙН ҮНДСЭН ҮЗҮҮЛЭЛТҮҮД

№	Дээж авсан гүн, см	pH	Давс, %	ЦДЧ, дс/м	Ялзмаг, %	CaCO <sub>3</sub> , %	NO <sub>3</sub> , мг/100г	Салхилах суурьнууд, мг-экв/100 г		Шингэ тээгээлтийн элементүүд, мг/100г	
								Ca <sup>2+</sup>	Mg <sup>2+</sup>	P <sub>2</sub> O <sub>5</sub>	K <sub>2</sub> O
Дээж 1											
1	20-30	6.82	0.014	0.034	6.59	0.32	0.27	22	11	1.7	19

2. ХӨРСНИЙ МЕХАНИК БҮРЭЛДЭХҮҮН

№	Дээж авсан гүн, см	Механик ширхэгүүд, % ширхэгийн хэмжээ, мм					
		1-0.25	0.25-0.05	0.05-0.01	0.01-0.005	0.005-0.001	<0.001
Дээж 1							
1	20-30	15.3	53.2	12.5	9.0	3.8	6.2

3. ХӨРСНИЙ ЭРҮҮД АХУЙН ШИНЖИЛГЭЭНИЙ ДҮН, ИГР ХӨРСӨНД

№	Дээж авсан дугаар	Нягтийн тоо MNS6341-2012		Гэгдсэн шидэвчлэлийн титр (E.coli)MNS 5367-2004		Анхорхойн (S.Crefringens) MNS 6341-2012	
		Шинжлэгээний хариу	Шинжлэгээний хариу	Бохирдлын зэрэг	Шинжлэгээний хариу	Бохирдлын зэрэг	
1	Дээж 1	4.1*10 <sup>3</sup>	1	1	0.1<	1	

4. ХӨРСНИЙ ХҮНД МЕТАЛЛЫН ҮЗҮҮЛЭЛТҮҮД

Дээж авсан газар, Газар зүйн байршил	Дээж авсан гүн, см	Хөрсний хүнд металлын агууламж, мг/кг						
		Cu	Pb	Cd	Zn	Cr	Ni	
Дээж 1		0-30	16.3	18.8	0.0	47.3	14.0	15.5
Товчоогордох дээд хэмжээ MNS 5850:2019								
Догдлох хөрө			60	50	1	100	60	60
Шавранцар хөрө			100	70	1.5	150	80	100
Шаварлаг хөрө			150	100	3	300	100	150

\*Цэгцлэлийн түүхийн Жив: Энэхүү шинжлэгээний хариу нь тухайн цэгийн дээжлэлд хамаарна.

ЗАДЛАН ШИНЖИЛГЭЭНИЙ АРГЫН СТАНДАРТУУД : Асрочийн гэрээгээр MNS3310:1991, MNS ISO10390, Механик бүрэлдэхүүн MNS6824:2020, Хүнд металлуудын хамт дарсанд атом шинжлэгээний спектрометрээр MNS ISO 11466:2007, Эрүүл Ахуйн Шинжлэгээний Стандарт MNS 5850:2019

ЗАДЛАН ШИНЖИЛГЭЭГ ГҮЙЦЭГТЭСЭН ГАНЦЭГ, Д.ЭНХЧИМЭГ ХЯНАСАН ЛАБОРАТОРИЙН ЭРХЛЭГЧ : ДОНГО Р.Д



2022-09-10 10:54:04 1



“НАРТ ШУУН КОНСАЛТИНГ” ХХК  
ХӨРСНИЙ ИТГЭМЖЛЭГДСЭН ЛАБОРАТОРИ



Монгол улс, Улаанбаатар хот, Сүхбаатар Хайрхан дүүрэг, 19-р хороо, ҮЗГ, ЗК 17024 Ш/х 10  
Утас: (976)-99176123, 99231836

E-mail: nartsumming@gmail.com

№ 22/09-30-1

Зөхөөлөгч: “Анлд Анлид” ХХК

Дээж авсан цэг: “Алтайн хангай бүрд” ХХК, Хэнтий аймаг Өвнөдэлгэр сум  
Сорьц авсан огноо: 2022 оны 09 сар 28 өдөр  
Уст шалгах төрөл: Сайхан гол

Борлуулт:

Харилцах утас:

Аргын стандарт: MNS1097:1970

Катион	1 дм <sup>3</sup>			Анион	1 дм <sup>3</sup>		
	мг/л	мг-экв/л	мг-экв/%		мг/л	мг-экв/л	мг-экв/%
Na <sup>+</sup>				CO <sub>3</sub> <sup>2-</sup>	0.0	0.0	0.00
K <sup>+</sup>	11.00	0.48	21.08	HCO <sub>3</sub> <sup>-</sup>	113.00	1.85	81.40
Ca <sup>2+</sup>	26.00	1.30	57.17	Cl <sup>-</sup>	11.50	0.32	14.26
Mg <sup>2+</sup>	6.00	0.49	21.75	SO <sub>4</sub> <sup>2-</sup>	0.50	0.01	0.62
				NO <sub>3</sub> <sup>-</sup>	3.00	0.08	3.72
Дүн	43.0	2.27	100	Дүн	128.0	2.27	100

Анион катионуудын нийлбэр:

ΣCa = 171 мг/л

HCO<sub>3</sub> ийн хагасыг хассан анион,

катионуудын нийлбэр: 114.5 мг/л

Физик зүүрхлэлтүүд

Өнгө: 0-өнгөгүй,

Үнэр: 0-үнэргүй

Булчгар: бага зэрэг

Хуурай үлдэгдэл, мг/л: 83 ppm

Ерөнхий хатуулаг: 1.79 мг-экв/л

бөөлөн ус

Урвалын орчин: pH- 7.98

Цахилгаан дамжуулах чадвар:

EC -0.214 дс/м

TDS: 116 ppm

$$M(0.17) = \frac{HCO_3 \text{ B1 [Cl 14]}}{Ca 57 [Mg 22 Na 21]}$$

Химийн бүрэлдэхүүнээрээ гидрокарбонатын анги, кальцийн бүлэг, I төрлийн нэм цэвэр дунд жинтэй эрдэстэй, бөөлөн ус.

Жив: усны сорьцыг шинжлэгээний байгуулалт дүнгээр харуулан оруулжээний болов.

ЗАДЛАН ШИНЖИЛГЭГЧ: Д.ЭНХЧИМЭГ ХЯНАСАН ЛАБОРАТОРИЙН ЭРХЛЭГЧ: Г.СОЛОНГО Р.Д



**10.БАЙГАЛЬ ОРЧНЫ МЕНЕЖМЕНТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨГ ХЭРЭГЖҮҮЛЭХ УДИРДЛАГА ЗОХИОН БАЙГУУЛАЛТЫН ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ БИЕЛЭЛТ**

*Хүснэгт 7. Удирдлага зохион байгуулалтын төлөвлөгөөний биелэлт*

Урьдчилан сэргийлэх, хамгаалах арга хэмжээ	Хэрэгжүүлсэн арга хэмжээ
Газрын төлөв байдал, чанарын улсын хянан баталгааг эрх бүхий байгууллагаар гүйцэтгүүлэх.	Газрын төлөв байдал, чанарын хянан баталгааны тайланг хийлгүүлэхээр мэргэжлийн байгууллага болох “Ашид ананда” ХХК-тай гэрээ байгуулсан. Гэрээний дагуу тус байгууллага нь тайланг боловсруулж дууссан бөгөөд дүгнэлтийг гаргуулахаар Барилга хот байгуулалтын яамны Газар зохион байгуулалт геодези зурагзүйн газар хүргүүлсэн болно.
Орон нутгаас тавьсан санал хүсэлтийг харилцан тохиролцож шийдвэрлэж байх	Орон нутагтай хамтран ажиллах гэрээг Хэнтий аймгийн Засаг даргатай байгуулан ажиллаж байна.
Байгаль орчны удирдлага зохион байгуулалтын арга хэлбэрийг үйл ажиллагаандаа хэрэгжүүлэх чиглэлээр үүрэг хариуцлагын дотоод журам тогтоож мөрдөх	Байгаль орчны мэргэжилтэн авч ажиллуулж байгаа болно. Байгаль орчныг хамгаалах, нөхөн сэргээх талаар мэдээллийг уурхайн ажилчдад тогтмол сургалт зохион байгуулж ажиллаж байна.
Байгаль хамгаалах талаар хийсэн ажлын жил бүрийн тайланг БОАЖЯ –нд хүргүүлэх.	Тайлангийн хугацаа болоогүй. Цахим тайлан илгээх эрхээ баталгаажуулсан болно.
Байгаль орчинд нөлөөлөх байдлын үнэлгээний тухай хууль, Байгаль хамгаалахад орон нутгийн иргэдийн оролцоог идэвхжүүлэх, уулзалт зөвлөгөөг зохион байгуулах, тэдний санал зөвлөмжийг БОХТ-г хэрэгжүүлэх ажилд тусгах	Орон нутгийн Төрийн захиргааны байгууллага болон багийн Засаг даргатай хамтран ажиллаж үйл ажиллагааны хугацаанд санал хүсэлт амаар болон бичгээр ирээгүй болно.

## 11.ОЛОН НИЙТЭД ТАЙЛАГНАХ ХУВААРЬ, ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ БИЕЛЭЛТ

Төслийн үйл ажиллагааны хүрээнд Байгаль орчны менежментийн төлөвлөгөөг хэрэгжүүлсэн ажлын тайлан, мэдээг танилцуулж, хэлэлцүүлэх ажлыг зохион байгуулахаар бичиг баримтын бүрдүүлэн, орон нутагт санал хүргүүлэн ажиллаж байна.

*Хүснэгт 8. БОМТ, түүний хэрэгжилтийг оролцогч, сонирхогч талуудад тайлагнасан биелэлт*

БОМТ хэрэгжилтийг тайлагнах, хэлэлцүүлэх байгууллагууд	Тайлагнах, хэлэлцүүлэх хэлбэр	Мэдээллийн агуулга	Хэрэгжүүлсэн арга хэмжээ
Байгаль орчны асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага	Цаасаар, цахимаар	БОМТ-ний хэрэгжилтийн талаар	Хуулийн хугацаа болоогүй
Байгаль орчны хяналтын улсын байцаагч, орон нутгийн байцаагч, Бүх шатны засаг дарга	Танилцуулж, тайлагнах	Тухайн жилийн БОМТ-ний хэрэгжилтийн талаар	Тус тайланг хянаж, дүгнэх ажлын хэсгийг томилуулах хүсэлт гаргасан.
Төслийн ажилчид ба орон нутгийн иргэдэд	Тайлагнах	Төслийн ажилчид ба орон нутгийн иргэдээс гомдол, санал гарсан тохиолдолд цаг алдалгүй санал гомдлыг нь барагдуулах зорилгоор гомдол барагдуулах менежментийн төлөвлөгөөг тогтвортой хэрэгжүүлэх;	2022 онд нутгийн иргэд болон орон нутгийн удирдлагуудаас уурхайн үйл ажиллагаатай холбоотой санал, гомдол ирээгүй болно.